



MONGOLIAN CASHMERE

МОНГОЛ УЛС
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 06 сарын 29-ны өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

Ногдол ашиг тараах хэлбэрийг өөрчлөх тухай

Говь ХК-ийн 2015 оны цэвэр ашгаас зарласан ногдол ашгийг тараах хэлбэрийг өөрчлөх тухай асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

Нэг. Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2016 оны 8 сарын 29-ний өдрийн 13-р тогтоолоор 2015 оны цэвэр ашгаас зарласан ногдол ашгийг компани дээрээ тарааж, хувьцаа эзэмшигчдэд хүссэн үед нь бэлэн мөнгөөр эсвэл харилцах дансанд нь шилжүүлэх арга хэлбэрээр олгохоор тогтоосныг хүчингүй болгосугай.

Хоёр. Говь ХК-ийн 2015 оны цэвэр ашгаас зарласан ногдол ашгийн үлдэгдэл тооцоог гарган, 2017 оны 6 сарын 30-ны өдрийн дотор Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төвөөр зуучлуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд шилжүүлэхийг Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан-д даалгасугай.

Гурав. Ногдол ашиг тараахтай холбогдон гарах зардлыг холбогдох зардлын төсвөөс гаргахыг Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан-д зөвшөөрсүгэй.

Дөрөв. Ногдол ашгийг Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төвөөр зуучлуулан тараахаар шийдвэрлэсэн тухай мэдээллийг зохих журмын дагуу хувьцаа эзэмшигчдэд хүргэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ-д даалгасугай.

ТУЗ-ийн ДАРГА:  Д.ГЭРЭЛМАА


ТУЗ-ийн ГИШҮҮД:  Ц.БААТАРСАЙХАН

 М.БАЯР

 Б.НАНДИН-ЭРДЭНЭ

 Т.ОДМАА

 Ж.ОЮУНЧИМЭГ

 ТАКЭШИ КАМБЭ

 ХИДЭО САВАДА

 Д.ХУЛАН